

НИЙТЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ТЭМДЭГЛЭЛ

**МАНАЙ СЭТГҮҮЛИЙН ТАЛААР ЗӨВЛӨЛТИЙН
ХЭВЛЭЛД БИЧСЭН НЬ**

ЗСБНХУ-ын ШУА-ийн Алс Дорнодын хүрээлэнгээс гардаг «Алс Дорнодын асуудал» хэмээх тогтмол сэтгүүлийн 1982 оны № 1-д зөвлөлтийн эрдэмтэн В. А. Архипов «БНМАУ-ын ШУА-ийн шинэ сэтгүүлийн хуудсаар» гэсэн гарчигтай нийтлэл хэвлүүлжээ. Түүнд бичихдээ: «БНМАУ-ын ШУА-ийн Дорнодахины судлалын хүрээлэн Алс дорнодын орнуудын түүх, эдийн засаг, төр эрх, соёл мөн түүнчилэн олон улсын харилцааны асуудлыг тусгах зорилгоор «Дорнодахины судлалын асуудал» хэмээх нийгэм-улс төрийн шинэ сэтгүүл гаргаж эхэлжээ» гээд «Дорнодахины судлалын асуудал» сэтгүүлийн 1981 оны № 1 (4)-т нийтлэгдсэн өгүүллүүдийн талаар тодорхой дүгнэн бичжээ. Үүнд: ЗХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүн М. И. Сладковскийн «Империализмын холбоотон их хан үндэстний жанжлах үзлийн түүхэн эх сурвалж» өгүүлэлд империалист бүлгүүд, юуны өмнө АНУ хятадын удирдагчтай ойртож байгаагийн шалтгаан, империалист бүлгүүдтэй ойртсоноос Хятадын хувьд олох «ашиг хонжоо»-г тодорхой шинжлэн дүгнэсэн нь чухал ач холбогдол- той болсоныг тэмдэглэжээ.

Д. Чулуундаваагийн «Улс түмний энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх түүхэн шинэ зорилт», Э. Пунцагийн «Афганистаны дөрөвдүгээр сарын хувьсгал», Д. Содномгомбо, Д. Баярхүү нарын «Бээжингийн гадаад бодлогын түрэмгий мөн чанар» зэрэг өгүүлэлд ЗХУКН-ын XXVI их хурлаас дэвшүүлсэн энх тайванч санаачлага, олон улсын хүнд байдлыг намжаан зөөлрүүлэх, дэлхийн янз бүрийн районд мөргөлдөөнийг энх тайван, хэлэлцээний замаар зохицуулахын төлөө ЗХУ-аас явуулж байгаа тууштай гадаад бодлогыг үнэлэхийн хамт Америкийн империализм, хятадын жанжлагчдаас олон улсын хэмжээнд явуулж байгаа хагалан бутаргах, хүчээр түрүү барих, юуны өмнө Зөвлөлт Холбоот Улсыг улс төр, үзэл суртлын талаар илт дайсагнах оролдлогыг илчлэн няцаасан зүйл оржээ. Бээжингийн их гүрний үндсэрхэг дээрэнгүй үзэлтнүүд намжмал байдлыг улайран эсэргүүцэж, олон улсын амьдралд гарч байгаа нааштай өөрчлөлт бүрийг жадлан эсэргүүцэх замаар империализмтэй бүх талаар эвсэн сүлбээлдэхийг оролдон улмаар хөгжиж байгаа орнуудыг нөлөөнийхөө онцгой бүс болгон хувиргаж, дэлхийн социалист системд сэргүүлэн тавих, эдгээр орны дотоод дахь харгис хүчийг дэмжих, эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний гол хандлага болох империализмыг эсэргүүцэх чиглэлийг нь алдагдуулах зорилго тавьж байгааг дээрхи өгүүллүүдэд онцлон тэмдэглэжээ.

Нийтлэлийн төгсгөлд Монголд гарсан энэхүү шинэ сэтгүүл Бүгд Найрамдах Монгол Ард Улс Азийн улс орнуудтай найрамдал, бүх талын хамтын ажиллагаагаа бэхжүүлэн өргөжүүлэх, энэ тивд бат бэх энх тайван, аюулгүй байдал тогтоох эрмэлзлэл төгс байгааг харуулаад зогссонгүй Ази тивийн улс орон, ард түмнүүдийн асуудалд монгол болон дэлхийн олон нийт анхаарлаа улам бүр хандуулж байдаг болсонтой холбоотой юм гэжээ.

Р. Отгон